



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр




Бүхэл ба бутархай хэсэгтэй энгийн бутархайг холимог бутархай гэж нэрлэж, тэмдэглэдэг. Жишээ:


$1 \frac{1}{6}$




1 Зургийг ажиглаж, холимог бутархайгаар бичээрэй.



2 Холимог бутархайг дүрслээрэй.



3 Зургийг ажиглаад, туузын уртыг холимог бутархайгаар бичээрэй.



4 Дүрсүүдийг тэнцүү хэсэгт хувааж, холимог бутархайгаар илэрхийлээрэй.



Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр




Тоон шулуун дээр энгийн бутархайг цэгээр тэмдэглэхэд их тоо нь бага тооныхоо баруун гар талд оршино.



Хүртвэр нь хуваарьтай тэнцүү бол нэг бүхэл, хуваариас их бол 1 бүхлээс их байна. Жишээ:

$$\frac{3}{5} < \frac{4}{5} < \frac{6}{5}$$


1) Тоон шулуун дээр $\frac{7}{5}$ бутархайг тэмдэглээрэй.



2) Тоон шулууныг ажиглаж, тоон хуваарийг гүйцээж бичээрэй.



3) Тоон шулуун дээр бутархайг тэмдэглээрэй. а. $1\frac{4}{5}$; $2\frac{2}{5}$ б. $5\frac{1}{2}$; $8\frac{1}{4}$



4) Бутархайг жишээрэй. а. $1\frac{4}{5} \dots 2\frac{3}{5}$ б. $5\frac{1}{2} \dots 8\frac{1}{4}$ в. $8\frac{1}{4} \dots 8\frac{3}{4}$

Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр





$1\frac{3}{4} = \frac{7}{4}$
 $\frac{7}{4} = 1\frac{3}{4}$


Холимог бутархайг засагдах бутархайд шилжүүлэхдээ бүхэл хэсгийг хуваариар үржүүлэн хүртвэрийг нэмж, хүртвэрт бичнэ.

Засагдах бутархайг холимог бутархайд шилжүүлэхдээ хүртвэрийг хуваарьт хувааж, ногдворын утгыг холимог бутархайн бүхэл хэсэгт, үлдэгдлийг хүртвэрт бичиж, хуваарийг хэвээр үлдээнэ.

1 Энгийн бутархайг харилцан шилжүүлж бичээрэй.



2 Засагдах бутархайг шилжүүлж, тоон шулуун дээр цэгээр тэмдэглээрэй.



3 Холимог бутархайг засагдах бутархайд шилжүүлж бичээрэй.

а. $1\frac{3}{2} = \frac{\square}{\square}$ б. $2\frac{4}{7} = \frac{\square}{\square}$ в. $3\frac{2}{6} = \frac{\square}{\square}$ г. $5\frac{3}{10} = \frac{\square}{\square}$

4 Ногдворыг холимог бутархайд шилжүүлж бичээрэй.

а. $3 \div 2 = \square \frac{\square}{\square}$ б. $5 \div 3 = \square \frac{\square}{\square}$ в. $9 \div 2 = \square \frac{\square}{\square}$ г. $7 \div 5 = \square \frac{\square}{\square}$

5 Энгийн бутархайг жишээрэй.

а. $1\frac{1}{2} \square \frac{5}{2}$ б. $2\frac{1}{2} \square \frac{10}{2}$ в. $\frac{14}{4} \square 4\frac{1}{2}$ г. $7\frac{1}{5} \square \frac{36}{5}$

Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4	5
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊	😊




Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Охин 5 м хөх тууз, түүнээс $\frac{2}{3}$ метрээр богино шар туузаар цэцэг хийв. Охин хэдэн метр шар туузаар цэцэг хийсэн бэ?



$$4 \frac{3}{3} - \frac{2}{3} = 3 + \frac{1}{3} = 4 \frac{1}{3} \text{ (м) шар тууз}$$

1 Бодлогыг дүрсэлж, бодоод шалгаарай.

Эмээ $5 \frac{2}{3}$ м олс, эгч $4 \frac{1}{3}$ м олс томов. Эмээ эгч хоёр нийлээд хэдэн метр олс томсон бэ?


2 Бодлогыг дүрсэлж, бодоод шалгаарай.

Сүүний үйлдвэрт ирсэн сүүний $\frac{3}{10}$ хэсэг нь хонь, $\frac{2}{10}$ хэсэг нь ямаа, үлдсэн хэсэг нь үнээний сүү байв. Нийт сүүний ямар хэсэг нь үнээний сүү вэ?

3 Бодлогыг туузаар дүрсэлж, бодоод шалгаарай.

Ногоочид $25 \frac{7}{10}$ т төмс, $45 \frac{1}{10}$ т лууван, луувангаас $4 \frac{3}{10}$ тонн бага байцаа хураан авав. Ногоочид нийт хэдэн тонн хүнсний ногоо хураан авсан бэ?

4 Зурагт тохирох бодлого зохиож бичээрэй.



Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4
Өөрийн үнэлгээ				




Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Хэсэгт ногдох хэмжээгээр уул тоо хэмжээг (бүтэн хэсэг) олох:

Ногоочин 60 кг төмс худалдав. Энэ нь бүх хураасан төмсний $\frac{3}{5}$ хэсэг бол ногоочин нийт хэдэн килограмм төмс хураасан бэ?




1) Нэг хэсгийн хэмжээг олох

$$60\text{кг} \div 3 = 20\text{ кг (1 хэсэг)}$$


2) Таван (бүтэн) хэсгийн хэмжээг олох

$$20\text{кг} \times 5 = 100\text{ кг (5 хэсэг)}$$

1) Сурагч 5000 төгрөгөөр үзэг авсан. Энэ нь түүнд байсан бүх мөнгөний $\frac{1}{3}$ -тэй тэнцүү бол сурагч анх хэдэн төгрөгтэй байсан бэ?



2) Дүү унших номынхоо 75 хуудсыг уншив. Энэ нь номын $\frac{3}{4}$ хэсэг бол дүү хэдэн хуудастай ном уншиж байгаа вэ?




3) Ангийн 18 сурагч шатрын тэмцээнд оров. Энэ нь ангийн хүүхдийн $\frac{2}{3}$ хэсэгтэй тэнцүү бол ангийн нийт хүүхдийн тоог олоорой. Хавтангаар дүрслээрэй.



4) Сургуулийн хашаанд 30 улиас ургадаг. Энэ нь бүх модны 5-ны 3 бол сургуулийн хашаанд нийт хэдэн мод ургадаг вэ? Дүрсэлж, бодоорой.



5) Загварт тохирох бодлого зохиож бодоорой.



Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4	5
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊	😊